

# МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

## Ангилалтын код 65.120

Мал аж ахуй. Монгол үүлдэр, омгийн адуу. Ерөнхий шаардлага	MNS 4099:2020
Livestock. Mongolian horse. General requirement	MNS 4099:2010-ын оронд

Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2020 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн С/49 дүгээр тушаалаар батлав.

Энэхүү стандарт нь 2020 оны 12 дугаар сарын 04-ний өдрөөс эхлэн хүчинтэй.

### 1. Зорилго

Монгол улсад үржүүлж буй нутгийн үүлдэр, омгийн адууны удмын санг хадгалах, чанарыг сайжруулах, цөм сүргийн адууг сонгон үржүүлэх, үржлийн адуу бойжуулж, борлуулахад оршино.

### 2. Хамрах хүрээ

**2.1** Энэхүү стандарт нь Монгол адууг удам гарваль, ашиг шимийн чиглэл, галбир бие цогцос, зүс, амьдын жин, биеийн үндсэн хэмжээ, үржлийн чанарыг нь харгалзан цөм, үржлийн, хэрэгцээний сүрэгт тавих шаардлагыг тогтооход хамаарна.

**2.2** Энэхүү стандартыг монгол үүлдэр, омгийн адуу үржүүлж, ашигладаг малчид, мал бүхий иргэд, байгууллага, аж ахуйн нэгжийн хооронд үүсэх харилцааг зохицуулахад хамаарна.

### 3. Норматив эшлэл

Энэ стандартад эш татаж хэрэглэсэн дараах стандарт болон норматив техникийн баримт бичигт өөрчлөлт орсон тохиолдолд тэдгээрийн хамгийн сүүлчийн хэвлэлийг хэрэглэнэ. Үүнд:

- *MNS 0407:1982 Үйлдвэр, экспортын бааз, худалдаа бэлтгэлийн байгууллагад адуу тушаах*
- *MNS 6688:2017 Автотээврийн хэрэгслээр мал амьтан тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага*

### 4. Нэр томъёо, тодорхойлолт

#### 4.1

#### Адуу

зоологийн ангиллаар сүүн тэжээлтний анги, туурайтны дээд баг, битүү туурайтны баг, адууны язгуур, адууны төрөлд хамаарах гэрийн тэжээвэр мал.

### 5. Ангилал

#### 5.1. Ашиг шимийн чиглэл:

5.1.1. Уналга, эдэлгээ-махны,

5.1.2. Уналга эдэлгээ- сүүний,

## MNS 4099:2020

### 5.1.3. Уналга, эдэлгээ-хурдны

### 5.2. Үүлдэрлэг байдал:

5.2.1. Үүлдэр: Монгол, Галшар, Тэс

5.2.2. Омог : Дархад, Мянгад, Өндөршил

### 1-р хүснэгт - Адууны нас

Сар	Нэр	Тайлбар
0-12	Унага	Эр, охин
13-24	Даага	Эр, охин
25-36	Шүдлэн	Эрийг үрээ, охиныг байдас
37-48	Хязаалан	Агтлаагүйг үрээ, охиныг байдас
49-60	Соёолон	Агтлаагүйг үрээ, охиныг гүү
60-аас дээш	Азарга	Үржлийн зориулалтаар сонгосон агтлаагүй эр адуу буюу хээлтүүлэгч
	Гүү	Үржлийн зориулалтаар ашиглах нас гүйцсэн хээлтэгч
	Морь	Нас гүйцсэн агталсан эр адуу

5.3. Монгол адууг удам гарваль, ашиг шимийн чиглэл, галбир бие цогцос, зүс, амьдын жин, биеийн үндсэн хэмжээ, үржлийн чанарыг нь харгалзан цөм, үржлийн, хэрэгцээний сүрэгт хамруулна.

5.4. Эрх бүхий байгууллагаас баталсан холбогдох зааврын дагуу, сум, дүүргийн мал үржлийн албаны мэргэжилтнүүд мал бүртгэлийн гэрчилгээн дээр тухайн үүлдэр, омгийн адууг аль сүрэгт хамааруулахыг тэмдэглэнэ.

## 6. Монгол адууны гадаад шинж байдал

6.1. Монгол үүлдрийн адуу: Уналга эдэлгээ-махны чиглэлтэй. Чийрэг бие цогцостой. Бие жижиг, толгой болхи, чих богино, нүд жижигдүү, бахим бүдүүн хүзүүтэй, өргөн гүн цээжтэй, урт, шулуун нуруутай, налуу хондлойтой, богино чийрэг, ясархаг хөлтэй, бат бэх шөрмөстэй. Хээр, хүрэн, зээрд, хул, хонгор зүс зонхилох боловч бусад зүсний адуу тодорхой хэмжээгээр тохиолдоно.

### 2-р хүснэгт - Цөм сүргийн адууны биеийн үндсэн хэмжээ, ашиг шимийн үзүүлэлт

Нас, хүйс	Биеийн үндсэн хэмжээ, см			Амьдын жин, кг	Хоногийн саам, л
	Сэрвээний өндөр	Цээжний бүслүүр	Шилбэний бүслүүр		
Азарга	135-139	156-169	17-20	315-400	
Гүү	130-134	148-165	16-18	280-380	3,0-4,0
Соёолон	132-137	146-157	16-18	280-320	
Хязаалан	128-130	141-156	16-17	250-285	
Шүдлэн	125-128	135-149	15-16	250-270	
Даага	122-125	119-134	14-16	212-245	



Монгол үүлдрийн азарга



Монгол үүлдрийн гүү

**6.2. Галшар үүлдрийн адуу:** Уналга эдэлгээ-хурдны чиглэлтэй. Чийрэг бие цогцостой, жижгэвтэр биетэй, хатингардуу хөнгөн толгойтой, хурц хараа, том биш босоо чихтэй, хөлийн шөрмөс тод илэрсэн, бат бэх цомбондуу туурайтай. Дэл, сүүл шингэн, арьс нимгэн, хурдны хэв шинж илүү тодорсон. Хүрэн, хээр, бор, хонгор, хар, хул, зээрд зүс зонхилдог.

**3-р хүснэгт - Галшар үүлдрийн адууны биеийн үндсэн хэмжээ, ашиг шимийн үзүүлэлт**

Нас, хүйс	Биеийн үндсэн хэмжээ, см			Амьдын жин, кг	Хоногийн саам, л
	Сэрвээний өндөр	Цээжний бүслүүр	Шилбэний бүслүүр		
Азарга	135-138	160-174	18-20	360-380	
Гүү	134-137	157-172	16-18	350-360	3,5-3,8
Хязаалан	133-139	152-162	16-17	280-320	
Шүдлэн	131-136	159-164	15-16	260-300	



Галшар үүлдрийн азарга



Галшар үүлдрийн гүү

**6.3. Тэс үүлдрийн адуу:** Уналга эдэлгээ-хурдны чиглэлтэй. Чийрэг бие цогцостой. Бие томтой, хатингардуу том толгойтой, монхор хамартай. Өд хэлбэрийн босоо соотон чихтэй, махлагдуу богино хүзүүтэй, өндөр босоо сэрвээтэй, өргөн шулуун зоо нуруу, өргөн гүн цээжтэй. Өвчүү, хөх мах тод илэрсэн, богтос чөмөг урт, булчин шөрмөс тод, гуя хонго тавиу боловч булчинлаг. Таван тэс говь удам нь далбагар том туурайтай бусад удам жижиг цомбон туурайтай, дэл, сүүл сахлаг, арьс зузаан. Тэс адуунд хээр, халтар, хүрэн, хар, хул бор, зүс зонхилдог.

**4-р хүснэгт - Тэс үүлдрийн адууны биеийн үндсэн хэмжээ,  
ашиг шимийн үзүүлэлт**

Нас, хүйс	Биеийн үндсэн хэмжээ, см			Амьдын жин, кг	Хоногийн саам, л
	Сэрвээний өндөр	Цээжний бүслүүр	Шилбэний бүслүүр		
Азарга	135-140	163-171	18-20	350-420	-
Гүү	134-138	161-174	17,5-19,5	340-400	3,0-3,5
Хязаалан	132-138	148-157	17-19	270-350	-
Шүдлэн	130-135	147-152	17-18,5	260-320	-



Тэс үүлдрийн азарга



Тэс үүлдрийн гүү

**6.4. Дархад омгийн адуу:** Уналга эдэлгээ-мах, сүүний чиглэлтэй. Богино бахим хүзүүтэй, цээж өргөн, гүн, гэдэс хэвлий том, булчингийн хөгжил сайтай, арьс нь зузаан, алхаа, хөдөлгөөн тайван, өтгөн дэл, сүүлтэй, хүч чадал сайтай. Махны гарцаар нутгийн адуунаас илүү, булчингийн завсрын өөхөн хуримтлал ихтэй. Дөрвөн хөл, туруу, ул таваг, ясны хөгжилт сайтай, сонор соргог, урт хөмсөг, урт хар сормуустай. Туруу нь ихэвчлэн хар. Сүүлэг чанар сайтай. Нийт сүргийн 70 орчим хувь нь цагаан, бүгээн зүстэй.

**5-р хүснэгт - Дархад омгийн адууны биеийн үндсэн хэмжээ,  
ашиг шимийн үзүүлэлт**

Нас, хүйс	Биеийн үндсэн хэмжээ, см			Амьдын жин, кг	Хоногийн саам, л
	Сэрвээний өндөр	Цээжний бүслүүр	Шилбэний бүслүүр		
Азарга	131-138	165-168	19-21	370-420	-
Гүү	128-136	161-174	18-19	340-400	3,6-4,1
Хязаалан	128-134	158-162	16-18	260-300	-
Шүдлэн	124-132	145-164	16-17	250-280	-



Дархад омгийн азарга



Дархад омгийн гүү

**6.5. Мянгад омгийн адуу:** Уналга эдэлгээ-махны чиглэлтэй. Чийрэг бие цогцостой. Том, лагс чамбай биетэй, өргөн, гүн цээжтэй, тэгш өргөн нуруутай, голдуу бөгрөгтэй, бөөрөнхий хондлойтой, арьс зузаан, сахлаг өтгөн дэл, сүүлтэй, харьцангуй том толгойтой, монхор хамартай, хамрын нүх уужим, хавирганы матаас сайн. Яс бат бөх, шөрмөс ил тод, цомбон туурайтай. Хээр, хүрэн, бор, хар, хул зүс зонхилдог.

**6-р хүснэгт - Мянгад омгийн адууны биеийн үндсэн хэмжээ, ашиг шимийн үзүүлэлт**

Нас, хүйс	Биеийн үндсэн хэмжээ, см			Амьдын жин, кг	Хоногийн саам, л
	Сэрвээний өндөр	Цээжний бүслүүр	Шилбэний бүслүүр		
Азарга	131-138	163-178	18-20	310-390	-
Гүү	130-136	168-176	17-19,5	300-365	3,0-3,5
Хязаалан	125-132	163-174	17-19	250-310	-
Шүдлэн	121-131	155-163	16-17	230-300	-



Мянгад омгийн азарга



Мянгад омгийн гүү

**6.6. Өндөршил омгийн адуу:** Уналга эдэлгээ-хурдны чиглэлтэй. Чийрэг бие цогцостой, дунд зэргийн хатингардуу толгойтой, өргөн духтай, шулуун хамартай, богино махлагдуу хүзүүтэй. Харьцангуй уртавтар бие, өргөн цээжтэй, өвчүү нь гадагшаа мэдэгдэхүйц төвийсөн. Шулуун нуруутай, бөөрөнхий унжуу хондлойтой. Шөрмөслөг богино чацтай, дэл, сүүл шингэн, жижиг далбан туурайтай. Булчин, шөрмөсний хөгжилт сайн. Хул, хээр, бор, цагаан, цайвар зүс зонхилдог.

**7-р хүснэгт - Өндөршил омгийн адууны биеийн үндсэн хэмжээ, ашиг шимийн үзүүлэлт**

Нас, хүйс	Биеийн үндсэн хэмжээ, см			Амьдын жин, кг	Хоногийн саам, л
	Сэрвээний өндөр	Цээжний бүслүүр	Шилбэний бүслүүр		
Азарга	135-139	165-175	18-20	370-390	-
Гүү	132-138	160-172	17-19	340-360	3,0
Хязаалан	129-134	153-168	17-18	300-370	-
Шүдлэн	126-131	147-156	16,5-18	250-300	-



Өндөршил омгийн азарга



Өндөр шил омгийн гүү

## **7. Тамга**

Монгол адууг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан “Малд им тамга тавих” зааврын дагуу зүүн гуяны доод хэсэгт иргэн, аж ахуйн нэгжийн тамгаар тамгална. Мөн хүйтэн аргаар тамгалж болно.

## **8. Ангилалтын хугацаа, үзлэг**

Монгол адууны ангилалтыг 9-10 дугаар сард Хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн сайдын тушаалаар баталсан зааврын дагуу хийнэ.

## **9. Тээвэрлэх, тууварлах**

Адууг “Авто тээврийн хэрэгслээр мал, амьтан тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага” MNS 6688:2017 стандартыг баримтлан тээвэрлэнэ.

**ТӨГСӨВ.**